



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/156

Шивээговь сум

**Золбин нохой муур устгах
 ажил зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны “Сумын 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд золбин нохой, муур устгалын ажлыг 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Золбин нохой муур устгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Д.Отгонжаргал (Засаг даргын
Тамгын газрын дарга)

Нарийн бичиг:

О.Отгонбаяр (Байгаль хамгаалагч)

Гишүүд:

С.Отгонбаатар (2 дугаар багийн
Засаг дарга)

Н.Амаржаргал (1 дүгээр багийн
Засаг дарга)

3. Золбин нохой муур устгалын зардалд зарцуулагдах 1.880.000 /Нэг сая найман зуун наян мянга/ төгрөгийг “Байгал орчин эрүүл ахуй, орчны бохирдолыг бууруулах-хоггүй сум” дэд хөтөлбөрийн төсвөөс зохих журмын дагуу гаргахыг нягтлан бодогч /М.Энхжаргал/-д зөвшөөрсүгэй.

4. Ажлыг чанартай зохион байгуулж, тайланг гарган танилцуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга / Д.Отгонжаргал/-д үүрэг болгосугай.



П.ГАНЧИМЭГ